

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/07/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Мөрөн сум 2023 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: lchinkhorloog@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ОХУ	Оросын Холбооны Улс



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.02.10 № 01/01
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ ДАХЬ
ГААЛИЙН ХОРООНЫ ДАРГА
Ч.САРАНХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөвсгөл аймгийн Ханх сум нь ОХУ-аас эрчим хүчээр хангагддаг бөгөөд агаарын давагдашгүй хүчин зүйл болон байнгын засвар үйлчилгээ хийхтэй холбоотой эрчим хүч тасрах тохиолдол гардаг байна. Тог тасрах нөхцөлд нөөц үүсгүүр болох 380 квт-ын мотор ажиллуулах шаардлага гардаг бөгөөд нөөц үүсгүүр ажиллуулах тээвэр шатахууны зардал хүрэлцдэггүй байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 он 01 дүгээр сарын 05-ны өдрийн 4 дүгээр тогтоол, УИХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан "Гаалийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль"-иар хорио цээр эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүрэг гаалийн байгууллагад шилжсэнтэй холбогдуулан ГЕГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 31-ний А/35 дугаар тушаалаар хилийн хорио цээрийн хяналтын 476,318.1 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хороо нь тайлант онд хэрэгжүүлэхээр нийт 4 зорилт 46 арга хэмжээг төлөвлөж 88 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /А.ЭРДЭНЭБААТАР/



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,398,653.98	18,905,767.98
35	БАРАА МАТЕРИАЛ	20,398,653.98	18,905,767.98
354	Хангамжийн материал	20,398,653.98	18,905,767.98
35410	Бичиг хэргийн материал	780,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	4,398,414.00	4,463,414.00
35440	Түлш, шатах тослох материал	8,500,780.00	11,760,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,719,459.98	2,682,353.98
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,329,071,477.15	1,270,946,176.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,329,071,477.15	1,270,946,176.29
392	Биет хөрөнгө	1,236,137,749.15	1,178,078,448.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,322,884,046.65	1,343,096,501.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	-234,747,336.00	-281,494,797.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,109,050.00	117,759,150.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-87,109,050.00	-100,867,379.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	401,985,271.70	856,402,872.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-259,858,363.72	-761,109,660.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,218,252.45	26,906,252.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,344,121.93	-22,614,491.01
393	Биет бус хөрөнгө	92,933,728.00	92,867,728.00
39301	Програм хангамж	980,000.00	980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-793,000.00	-859,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	92,746,728.00	92,746,728.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,349,470,131.13	1,289,851,944.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,349,470,131.13	1,289,851,944.27
51	Засгийн газрын хувь оролцоо	1,349,470,131.13	1,289,851,944.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	876,068,398.79	876,068,398.79
512	Хуримтлагдсан үр дүн	388,290,298.81	328,672,111.95
51210	Өмнөх үеийн үр дүн	452,027,474.68	388,290,298.81
51220	Тайлант үеийн үр дүн	-63,737,175.87	-59,618,186.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,111,433.53	85,111,433.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,349,470,131.13	1,289,851,944.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	351,666,310.00	529,706,765.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,202,110.00	37,157,665.79
120	Нийтлэг татварын бус орлого	2,202,110.00	37,157,665.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,202,110.00	37,157,665.79
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	576,000.00	576,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,626,110.00	36,581,665.79
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	349,464,200.00	492,549,100.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	348,464,200.00	492,549,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	348,464,200.00	492,549,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	415,379,065.87	589,002,344.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	415,379,065.87	589,002,344.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,740,794.56	533,166,097.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,201,938.11	338,374,080.46
210101	Үндсэн цалин	128,625,105.42	195,016,748.59
210102	Нэмэгдэл	57,585,990.31	84,279,386.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,918,319.58	27,908,008.41
210104	Урамшуулал	17,072,522.80	31,169,936.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,431,573.58	41,654,874.10
210201	Тэтгэврийн даатгал	19,672,292.06	28,708,913.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,980,707.10	3,377,519.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,523,092.00	2,702,015.51
210204	Ажилгүйдлийн даатгал	396,141.36	624,220.49
210205	Эрүүл мэндийн даатгал	3,859,341.06	6,242,205.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,529,902.00	22,026,236.30
210301	Гэрэл, цахилгаан	5,522,731.00	8,226,700.00
210302	Түлш, халаалт	10,807,970.00	13,476,301.60
210303	Цэвэр, бохир ус	199,201.00	323,234.70
2104	Хангамж, бараа материалын зардал	14,836,437.30	16,616,212.20
210401	Бичиг хэрэг	1,544,500.00	2,863,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,536,000.00	12,080,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	534,157.00	257,462.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	266,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,228,000.00	1,148,850.00
210408	Бараа материал акталсны зардал	933,780.30	00.00
2105	Нормативт зардал	00.00	2,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,385,220.00	16,687,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	225,000.00	381,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,590,700.00	8,306,250.00
210604	Урсгал засвар	4,569,520.00	8,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,039,200.00	1,193,200.00
210702	Дотоод албан томилолт	1,039,200.00	1,193,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,766,228.00	1,523,086.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	232,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	751,718.00	887,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	133,900.00	130,000.00
210807	Газрын төлбөр	209,310.00	179,730.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	395,300.00	271,356.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,550,295.57	93,090,858.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,000.00	00.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,420,295.57	93,090,858.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,638,271.31	55,836,246.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,638,271.31	55,336,246.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,638,271.31	55,336,246.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-63,712,755.87	-59,295,578.86
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,420.00	322,608.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	24,420.00	322,608.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-24,420.00	-322,608.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-63,737,175.87	-59,618,186.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	350,120,200.00	493,125,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	656,000.00	576,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	656,000.00	576,000.00
120005	Түрээсийн орлого	656,000.00	576,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	349,464,200.00	492,549,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	348,464,200.00	492,549,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	348,464,200.00	492,549,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	243,633,511.69	493,125,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	243,633,511.69	493,125,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	300,891,648.69	437,288,853.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,201,938.11	338,374,080.46
210101	Үндсэн цалин	128,625,105.42	195,016,748.59
210102	Нэмэгдэл	57,585,990.31	84,279,386.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,918,319.58	27,908,008.41
210104	Урамшуулал	17,072,522.80	31,169,936.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,431,573.58	41,654,874.10
210201	Тэтгэврийн даатгал	19,672,292.06	28,708,913.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,980,707.10	3,377,519.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,523,092.00	2,702,015.51
210204	Ажилгүйдлийн даатгал	396,141.36	624,220.49
210205	Эрүүл мэндийн даатгал	3,859,341.06	6,242,205.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,596,932.00	25,285,456.30
210301	Гэрэл, цахилгаан	5,522,731.00	8,226,700.00
210302	Түлш, халаалт	13,875,000.00	16,735,521.60
210303	Цэвэр, бохир ус	199,201.00	323,234.70
2104	Хангамж, бараа материалын зардал	14,802,657.00	15,716,212.20
210401	Бичиг хэрэг	2,324,500.00	2,083,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,536,000.00	12,080,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	534,157.00	257,462.20

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	266,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,348,000.00	1,028,850.00
2105	Нормативт зардал	00.00	2,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,573,120.00	11,813,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,421,900.00	381,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,581,700.00	3,432,000.00
210604	Урсгал засвар	4,569,520.00	8,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,039,200.00	1,193,200.00
210702	Дотоод албан томилолт	1,039,200.00	1,193,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,116,228.00	1,251,730.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	582,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	650,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,718.00	237,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	133,900.00	130,000.00
210807	Газрын төлбөр	209,310.00	179,730.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	395,300.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,130,000.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,638,271.31	55,836,246.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,638,271.31	55,336,246.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,638,271.31	55,336,246.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	106,486,688.31	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,590,280.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,590,280.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,590,280.00	00.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	17,590,280.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-17,590,280.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	88,896,408.31	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,068,398.79	85,111,433.53	452,027,474.68	1,413,207,307.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,068,398.79	85,111,433.53	452,027,474.68	1,413,207,307.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-63,737,175.87	-63,737,175.87
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,068,398.79	85,111,433.53	388,290,298.81	1,349,470,131.13
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,068,398.79	85,111,433.53	324,553,122.94	1,349,470,131.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,068,398.79	85,111,433.53	388,290,298.81	1,349,470,131.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-59,618,186.86	-59,618,186.86
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,068,398.79	85,111,433.53	328,672,111.95	1,289,851,944.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төгрөгөөр/
				Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	493,509,100.0	437,788,853.1	55,720,246.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	493,509,100.0	437,788,853.1	55,720,246.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	493,009,100.0	437,288,853.1	55,720,246.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,252,800.0	338,374,080.5	43,878,719.5
210101	Үндсэн цалин	215,645,700.0	195,016,748.6	20,628,951.4
210102	Нэмэгдэл	105,867,100.0	84,279,386.9	21,587,713.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,740,000.0	27,908,008.4	-2,168,008.4
210104	Урамшуулал	35,000,000.0	31,169,936.6	3,830,063.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,619,100.0	41,654,874.1	6,964,225.9
210201	Тэтгэврийн даатгал	35,069,000.0	28,708,913.6	6,360,086.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,387,500.0	3,377,519.3	9,980.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,710,000.0	2,702,015.5	7,984.5
210204	Ажилгүйдлийн даатгал	677,500.0	624,220.5	53,279.5
210205	Эрүүл мэндийн даатгал	6,775,100.0	6,242,205.2	532,894.9

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,037,900.0	25,285,456.3	2,752,443.7
210301	Гэрэл, цахилгаан	8,226,700.0	8,226,700.0	00.0
210302	Түлш, халаалт	19,468,000.0	16,735,521.6	2,732,478.4
210303	Цэвэр, бохир ус	343,200.0	323,234.7	19,965.3
2104	Хангамж, бараа материалын зардал	16,600,600.0	15,716,212.2	884,387.8
210401	Бичиг хэрэг	2,192,700.0	2,083,000.0	109,700.0
210402	Тээвэр, шатахуун	12,080,000.0	12,080,000.0	00.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	917,000.0	257,462.2	659,537.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	266,900.0	266,900.0	00.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,144,000.0	1,028,850.0	115,150.0
2105	Нормативт зардал	2,000,000.0	2,000,000.0	00.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000,000.0	2,000,000.0	00.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,813,300.0	11,813,300.0	00.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	381,300.0	381,300.0	00.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,432,000.0	3,432,000.0	00.0
210604	Урсгал засвар	8,000,000.0	8,000,000.0	00.0
2107	Томилолт, зочны зардал	1,258,400.0	1,193,200.0	65,200.0
210702	Дотоод албан томилолт	1,258,400.0	1,193,200.0	65,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,427,000.0	1,251,730.0	1,175,270.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.0	00.0	1,080,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.0	650,000.0	00.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,000.0	237,000.0	00.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.0	55,000.0	25,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	130,000.0	130,000.0	00.0
210807	Газрын төлбөр	250,000.0	179,730.0	70,270.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.0	500,000.0	00.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.0	500,000.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.0	500,000.0	00.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	492,549,100.0	492,549,100.0	00.0
120	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	960,000.0	576,000.0	384,000.0
120005	Төрийн өмч түрээслүүлсний орлого	960,000.0	576,000.0	384,000.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	492,549,100.0	437,212,853.1	55,336,246.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	492,549,100.0	437,212,853.1	55,336,246.9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хороо нь Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэх эрхэм зорилгын хүрээнд Гаалийн байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг гаалийн бодлого, тэргүүлэх чиглэл, стратегитай уялдуулан хөгжүүлж, өргөжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд Засгийн газрын 192 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ”-г шинэчлэн тогтоосонтой холбоотой Хөвсгөл аймгийн ханх дахь Гаалийн хорооны даргын 2022 оны Б/13 дугаар тушаалаар үйлчилгээний албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон байна.

Тайлант оны 5 дугаар сараас Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Төсөв хэмнэх тухай Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар албан даалгаврыг харьяа Гаалийн хороодод хүргүүлэн хэрэгжүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: ГЕГ-ын дэргэдэх Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газраас ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодын дотоод хяналт хэрэгжүүлэх журам, зааврыг боловсруулж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд Ханх дахь Гаалийн хороонд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мөн Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.1-д заасны дагуу тус гаалийн хороон даргын тушаалаар дотоод хяналтын баг томилон ажиллуулж байна. Дотоод хяналтын баг нь байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу улирал бүр дотоод хяналт хийн ажиллаж байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/272 дугаар тушаалаар баталсан “Гаалийн газар, харьяа газар, хороодын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,618.2 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	20,398.6	18,905.8	1,492.8
Үндсэн хөрөнгө	1,329,071.5	1,270,946.2	58,125.3
Нийт хөрөнгө	1,349,470.1	1,289,851.9	59,618.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	876,068.4	876,068.4	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,349,470.1	1,289,851.9	59,618.2

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 58,125.3 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүд байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,099,378.9 мянга, нийт зарлагыг 1,099,378.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 674,433.1 мянган төгрөгөөр бууруулж, 424,945.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг боловсруулахдаа Ханх боомт нь олон улсын боомт болохтой холбогдуулан гарах зураг төсвийн болон дагалдах урсгал засварын зардлыг 700,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 68,563.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 493,509.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 960.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 437,788.8 мянган төгрөг буюу 88.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 43,878.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардлыг 6,964.2 мянган төгрөг, тогтмол зардлыг 2,752.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,175.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70205/80101	492,049.1	436,712.8	55,336.2	88.7%
2	70205/80802	500.0	500.0	0.00	100%
Нийт дүн		492,549.1	437,212.8	55,336.2	88.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсөв байхгүй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитор Г.Ичинхорлоо нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, газрын захирал, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 451,379.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9,027.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илэрсэнгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
 - Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ
 - Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл
1. Дээрх асуудлын хүрээнд нийт 24 мэдээлэл байршуулахаас 22 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.
 2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 492,549.1 мянган төгрөгийн 13 гүйлгээ, зарлагын 7,600.0 мянган төгрөгийн 1 гүйлгээний мэдээллийг 100 хувь хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд мэдээлсэн, 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илэрсэн 3.7 сая төгрөгийн 1 зөрчилд Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолоор баталсан эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдлөг болгох, урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах тухай 1 зөвлөмж өгсөн. Тайлант онд урсгал зардлаас хөрөнгө бэлтгээгүй бөгөөд зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй зөрчил дахин давтагдсан байна. Энэ нь төсвийн төсөл бэлтгэхдээ эдийн засгийн ангиллаа буруу тооцоолсонтой холбоотой байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	3,700.0	1	3,337.0	90.1%
Нийт дүн	1	3,700.0	1	3,337.0	90.1%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны санхүүгийн тайланд аудит хийхэд нягтлан бодогчийн баримт бүрдүүлэлт, бүртгэл хөтлөлт, холбогдох хуулийн хэрэгжилт, шилэн дансны хөтлөлт зэрэг санхүү бүртгэлийн үйл ажиллагаа “хангалттай” байгаа тул дараагийн аудитаар анхаарч үзэх асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 363.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 363.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас 206.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, багаж техник хэрэгслийн зардлаас 156.1 мянган төгрөгийн засварын үйлчилгээний хөлс шилжүүлсэн 1 зөрчил илэрсэн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан эдийн засгийн ангилал ашиглах зааварт нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолоор баталсан эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдлөг болгон ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

